

ЁГТ НЭРИЙН УХААНД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

Ц.Түмэн-Өлзий - МУИС. МХСС. Эх бичиг судлалын тэнхим, докторант

Түлхүүр үгс: илт нэр, Буддын шашин, зурхай, яруу найраг, анагаах ухаан, эх сурвалж, хэрэглээ.

Товч утга: Эл өгүүлээрээ Бурханы шашны зарим мэдлэг ухаан дахь ёгт нэрийн хэрэглээний тухай, төвд хэлт эх сурвалжуудын тухай судалгаа шинжилгээний хүрээнд татан оруулах оролдлогыг хийж байгаа болно. Ёгт нэр нь Буддын арван ухаанд ихэнхэд нь их, бага янз бүрийн хэмжээгээр хэрэглэгддэг. Тэдгээрээс зурхай, яруу найраг, анагаах ухаанд ёгт нэрийн хэрэглээ маш өргөн ашиглагддаг.

“Илт өгүүлэх ёгтыг мэдвээс нэр дор үл мунхармуй”.¹⁷¹ V Далай лам
Агваанлуvsанжамц

Ёгт нэрийн тухай. Буддын шашны таван бага ухаанд яруу найраг \nyan dngags\, ёгт нэр \mngon brjod\, холбон найруулга \sdeb sbyor\, бүжиг \zlos gar\, одон зурхай \dkar rtsis\ ордог бөгөөд V Далай лам Агваанлуvsанжамц \ngag dbang blo bzang rgya mtsho\ “Таван бага ухаанд таалагч нугуудын мэдэх хэрэгтэй нь яруу найргийг мэдвээс үгийн чимгэнд үл мунхарна, ёгт нэрийг мэдвээс нэрэнд үл мунхарна, холбон найруулгийг мэдвээс шүлэгт үл мунхарна, бүжиг хөгжмийг мэдвээс дууны язгуурт үл мунхарна” хэмээн зарлигласныг Зая бандид \dza' ya bantita\ Лувсанпэрэнлай \blo bzang 'phrinlas\ “Шагжийн тойн Лувсанпэрэнлайн гүнзгий ба агуу их дээдийн номын товъёог тодруулагч толиос нэгдүгээр боть оршвой”¹⁷² хэмээх номондоо дурьдсан байна. Ёгт нэрийг Энэтхэгийн дөрвөн хэлний нэг болох санскрит хэлээр

ཨ་མི་དཀར་ཀླུ་མཁའ་འཁོར་གྱི་མཁའ་འཁོར་བཟོ་བ་ལྟར་བྱ་བ་ sam skri ta skad du abhi dha na/ авхи дана гэж бичдэг бол

Төвд хэлээр འོ་བོད་སྐད་ཀྱི་མཁའ་འཁོར་གྱི་མཁའ་འཁོར་བཟོ་བ་ལྟར་བྱ་བ་ /bod skad du mngon brjod ming/ онжод мин гэж бичдэг билээ.

Монголоор илт өгүүлэх нэр ба ёгт нэр хэмээн нэрлэдэг. Зарим нэгэн төвд монгол толь бичгийн тайлбарыг авч үзвэл Өвөр Монголын Алагшаа хошууны лхарамба Агваандандарын \ngag dbang bstan dar \ /1758-1840/ зохиосон “Нэр утгыг тодруулагч сарны гэгээн гэрэл хэмээгдэх дохионы бичиг оршвой”¹⁷³ хэмээх номонд ёгт нэрийг *нэрийн зүйлийн илэрхий өгүүлэл* гэж бичсэн бол XIX-р зууны үед Ишдорж¹⁷⁴ \yi shes rdo rje \ гэдэг хүн найруулан зохиосон “Төвд

¹⁷¹ Зая бандид Лувсанпэрэнлайн зохиол “Шагжийн тойн Лувсанпэрэнлайн гүнзгий ба агуу их дээдийн номын товъёог тодруулагч толиос нэгдүгээр боть оршвой” 65-р хуудас

¹⁷² Sha kya'i btsun ba blo bzang 'phrinlas kyi zab ba dang rgya che b'i dam pa'i chos kyi thob yig gsal pa'i me long las glegs bam dang po bzhugs so

¹⁷³ Brda' yig ming don gsal bar byed p'i zla b'i 'od snang zhe bya ba bzhugs so. Уг толь бичгээ Агваандандар лхарамба Манжийн төр гэрэлт хааны 18-р он буюу нийтийн тооллын 1838 онд 80 насандаа зохиожээ.

¹⁷⁴ Ишдорж нь монгол үсэг мэдэхгүй учраас монгол үгийг төвд үсгээр өөрийн нутгийн аман аялгууг баримтлан тэмдэглэжээ. Зохиогч Ишдоржийн тухай тодорхой мэдээлэл олдодгүй боловч аман аялгуун дээр түшиглэсэн бичлэгийг харахад баруун аймгийн хүн байсан нь илт байна.

хэлний шинэ хуучин дохионы бэрхийг монгол хэлний гийгүүлэгч гучин үсэгний дарааллаар нягтлан буулгасан дохионы бичиг мэргэдийн далай оюун тодорхой хүзүүний чимэг хэмээх оршвой”¹⁷⁵ гэдэг толь бичигт *нэр өгүүлэх, нэр илэрхий өгүүлэх* гэж бичсэн байна.

Монголчуудын гол хэрэглээ болж ирсэн Буриадын Сумадирадна¹⁷⁶ /su ma ti rata na/ буюу Лувсанринчэнгийн /blo bzang rin chen / зохиосон “Төвд Монголын дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул оршвой”¹⁷⁷ номонд *өгт, өгтой, шүүмжлэл, өгүүлэл, өгт нь аливаа юмыг оньсого таавраар нэрийдэх нь үлгэрлэвээс сарыг “туулайт” хэмээх мэт, бас үүн лугээ залгамжилж орсон үг мэт. Ёгт нь нэгэн нэр дор олон утга орох хийгээд нэгэн утга дор олон нэр орох ёсыг тодорхой үйлдэгч* гэжээ.

Мөн өөр нэгэн хувилбар бол Буриадын Гирдийбазарын \ki rti bdzara\ зохиосон “Төвд Монголын дохионы бичиг нэр, үг, утга гурвыг тодруулагч оршвой”¹⁷⁸ хэмээх төвд монгол хадмал тольд *нэр өгүүлэх, ил өгүүлэх* гэсэн бол Агийн Дэчинлхүндэвлин \bde chen lhun grub gling\ дацангийн Цорж Төгөлдөрийн Галсанжинба \bskal bzang spyin pa\ буюу мэндгүй цоржийн бичсэн “Нэр утгыг гийгүүлэгч зул хэмээгдэх дохионы бичиг оршвой”¹⁷⁹ хэмээх хадмал толь бичигт *нэрт зүйлийн илэрхий өгүүлэл* гэжээ.

Их хүрээний бандида Нүүрний хэмээн алдаршсан Цэрэндоржийн \tshe ring rdo rje\ бичсэн гар бичмэл 303 хуудастай толь бичигт *нэр өгүүлэх, илт өгүүлэх, хатуу нэр, өгт* гэсэн байна. Илт өгүүлэх гэдэг нь алив нэг юмыг олон янзаар, олон талаас нь үзэж өгсөн далд утгатай нэр гэж хэлж болох юм.

Энэ мэтчлэн өгт нэр хэмээхийн тухайд хэлзүйн талын олон тайлбар байх боловч утгын хувьд нэг л онцлогтой. Ёгт нэрийн энэхүү нэг зүйлийг олон янзаар нэрлэх нь нэг талаасаа бурхны шашны мэдлэг ухааныг нийтийн ба нийт бусын ухаан хэмээн ангилан үзэж нийт бусын ухааныг нууцлах үүднээс хэрэглэж ирсэн гэж үзэж болох юм. Энэ мэтчлэн өгт нэр нь олон онцлог шинжээрээ орчин үеийн судлаач эрдэмтдийн анхаарлыг татсан судалгааны нэг болоод байна.

Сүүлийн жилүүдэд Монгол судлалд илт өгүүлэх нэрийн тухай бичигдсэн өгүүлэлээс дурдвал: О.Сүхбаатар “Илт өгүүлэх нэрийн асуудалд”¹⁸⁰ Л.Тэрбиш

¹⁷⁵ Bod skad kyi brd' gsar rnying dk' ba sog skad du k' li sum cu'l rim bas gtan la pheeb p'l brda' yig mkhas rgya mtsho blo gsal mgul rgyan ces bya ba bzhugs so.

Corpus scriptorum mongolorum. Instituti linguae et litterarum comiteti scientiarum et educationis altae reipublicae populi mongoli. Tomus IV 1959

¹⁷⁶ Сумадираднагийн толь бичиг гэж алдаршсан бөгөөд Буриадын сургуулийн яамны туслагч түшмэл өтөл Сумадирадна бээр өөрийн 57 насан дээр 15-р жарны улаагчин үхэр жилд найруулав гэж төгсгөлийн үгэнд бичсэн байна. Энэ нь нийтийн тооллын 1877 он юм.

¹⁷⁷ Bod hor gyi brda yig ming tshig don gsum gsal bar byed p'l mun sel sgron me bzhugs so.

Corpus scriptorum mongolorum. Instituti linguae et litterarum comiteti scientiarum et educationis altae reipublicae populi mongoli. Tomus VI 1959

¹⁷⁸ Bod hor kyi brda yig ming tshig don gsum gsal byed bzhugs

¹⁷⁹ Brda yig ming don gsal b'l sgron me zhes bya ba bzhugs so

¹⁸⁰ Studia lingua et litterarum instite linguae et litterarum academiae scientiarum reipublicae populi mongolici tom XIV fasc 13 Ulan-bator 1980

“Зурхайн илт өгүүлэх нэрийн асуудалд”¹⁸¹ Ш.Сонинбаяр “Яруу найрагт ёгт нэрийг хэрэглэж ирсэн уламжлалаас”¹⁸² зэрэг өгүүлэлүүд орно. Л.Тэрбиш “Зурхайн ухааны нэр, утгыг гийгүүлэгч түлхүүр толь бичиг” нэртэй зурхайн ёгт нэрийн тухай ном бичсэн бол, хамгийн сүүлд бичигдсэн ёгт нэрийн дорвитой бүтээлүүдийн нэг бол Д.Бүрнээ Д.Энхтөр нарын эмхэтгэн хэвлүүлсэн “Төвд Монгол илт өгүүлэх нэрийн толь”¹⁸³ /*bod hor mngon brjod kyi brda yig*/ билээ. Ийнхүү монгол эрдэмтэд ёгт нэрийн ухааныг судлан сонирхох нь бурхны шашин монголын уламжлалт шашин төдийгүй түүхэнд нийгмийн голлох үзэл суртал болтлоо хөгжсөн үе зэрэг хүчин зүйлээс үүдэлтэй байх.

Харин Төвд орны тухайд бол бурхны шашны өлгий нутгийн нэг учраас тус шашны эх сурвалжуудыг өөрийн хэлээр туурвин уламжлалаа хадгалсаар ирснийг ёгт нэрийн судалгааны зарим сурвалжаас харж болно. Энэтхэгт Бурханы шашин дэлгэрсэнээс хойш тус орны олон мэргэд ёгт нэрийн зохиол бүтээл туурвиж байжээ. Энэтхэгээс үүсэлтэй илт өгүүлэх нэрсийн хамгийн анхны толь бичиг гэж үздэг “Амра Синха”-гийн толь “Ёгт нэрийн шашдир үхэлгүйн гуу сан”¹⁸⁴ зохиолыг Энэтхэгийн мэргэн Чимэдсэнгээ *'chi med seng gel* зохиож Төвдийн мэргэн Ярлүдбадагбажалцан *lyar lung ba grag pa rgyal mtshan* бээр Балба орны Ямбү *lyam bu* хотод төвд хэлэнд орчуулжээ. Чимэдсэнгээ уг зохиолоо өөрийнхөө нэрээр нэрлэсэн бөгөөд уг зохиол нь нийт 15 аймгаас бүрдэнэ.

1. Өндөр язгуурын аймагт тэнгэр ба тэнгэр бус, нар, сар, гариг, од, хур, үүл, буян, хилэнц, өнгө, хөгжим, бүжиг тэргүүтний ёгт нэрийн зүйл.
2. Доод газрын аймагт харанхуй ба там, зовлон, далай, нуур, мэлхий, могой, дун, удвал, бадам тэргүүтний ёгт нэрийн зүйл.
3. Газрын аймагт дэлхий ба зам тэргүүтний ёгт нэрийн зүйл.
4. Хот балгадын аймагт хот балгад, байшин, орд харш тэргүүтний ёгт нэрийн зүйл.
5. Уулын аймагт уул ба орчин тойрон, эгц уул тэргүүтний ёгт нэрийн зүйл.
6. Ой ба эмийн аймагт модны ба эмний язгуур тэргүүтний ёгт нэрийн зүйл.
7. Арслан тэргүүтний аймагт арслан, гахай, бич, чоно, муур, хөхөө, тогос, зөгий, эрвээхэй, шувууны өд тэргүүтний ёгт нэрийн зүйл.
8. Хүний аймагт ерөнхий хүн, эр, эм, бэр, ач, эмч, бие, мөч, чимэг, хувцас тэргүүтний ёгт нэрийн зүйл.
9. Барамсайн язгуурын аймагт барамсай, язгуур, угсаа, мэргэн тэргүүтний ёгт нэрийн зүйл.

¹⁸¹ *Studia mongolica permanent committee international congress of mongolists* tom XIII /21/ fasc 14 Ulan-bator 1985

¹⁸² *Studia mongolica permanent committee international congress of mongolists* tom XIII /21/ fasc 1-21 Ulan-bator 1987

¹⁸³ *Tibetan Mongolian dictionary of synonyms* Ulaanbaatar 2003

¹⁸⁴ *Mngon brjod kyi bstan bcos 'chi ba med p'i mdzod ces bya ba bzhugs so*. Хөх нуурын ардын хэвлэлийн хороо. 1995 он

10. Хааны язгуурын аймагт хаан, түшмэл, дайсан, зурхайч, бичээч, дөрвөн гишүүний цэрэг, сум, хутга тэргүүтний ёгт нэрийн зүйл.

11. Ноёны язгуурын аймагт ноён, тариа, төмс, тариалан, үрийн язгуур, үхэр, алт, мөнгө, төмөр тэргүүтний ёгт нэрийн зүйл.

12. Доорд язгуурын аймагт доорд язгууртан, архи, өрөм, цоолтуур, олс, сур зэрэг багаж хэрэгслэл тэргүүтний ёгт нэрийн зүйл.

13. Өвөрмөгц бусдын эрхт аймаг.

14. Холимогын аймаг.

15. Утга бүгдийн аймаг зэргээс бүрэлдсэн байна. Түүний тайлбарыг Бандида Равжордава \panti ta rab 'byor zla ba\ зохиосон ба "Хүслийг хангагч"¹⁸⁵ нэртэй билээ. "Амра Синха"-гийн толь Монгол Данжурын 205-р ботид байдаг байна.

Үүнээс гадна Монгол Данжурын 221-р ботид "Илт өгүүлэхийн шасдир элдэв зүйлийн тодруулагч бус нэрийн сувдан эрх хэмээгдэх" гэсэн нэртэй том толь байна.¹⁸⁶

XIII-р зуунаас өмнө Төвдийн их орчуулагч Шондондоржжалцан \ Shong ston rdo rje rgyal mtshan\ бээр Энэтхэг хэл дээрхи судар шастирын ёгт нэрийн гол ном болох "Яруу найргийн толь",¹⁸⁷ "Галбираасан ороонго мод"¹⁸⁸, "Лус бүгдийг баясуулагч"¹⁸⁹ зэрэг эх сурвалжуудыг төвд хэл дээр орчуулжээ.

Их бандида Балданбалзіндэгийн \dpal ldan dpal 'dzin sde\ туурвисан "Ёгт нэрийн элдэв тодруулга"¹⁹⁰, Жамъянсабангийн \jam dbyangs sa pan\ "Үгийн гуу сан"¹⁹¹, түүний тайлбарыг Лоданшива \blo brtan bzhi pa\ зохиосон ба Нартан лозава \snar thang lo tsa ba\ Сангааширийн \sang gha shri\ "Ёгт нэрийн алтан эрхэсээр цэнгэгч"¹⁹², Балганлозавийн \dpal sgang lo tsa ba\ "Ёгт нэрийн цагаан лянхуан эрхэс"¹⁹³, Сүрхарва Лодойжалбуугийн \zur mkhar ba blo gros rgyal po/ "Ёгт нэрийн шастир гурван үетын зүрхэн"¹⁹⁴ тэргүүтэн судрууд байдаг байна.

Төвдийн мэргэдийн ёгт нэрийн бүтээл олон байдаг боловч ард түмний дунд хамгийн их алдаршсан нь Дэбаринбүнба Агваанжигдагын¹⁹⁵ \sde rin spungs pa 'ag dbang 'jigs grags\ зохиол "Ёгт нэрийн шастир мэргэдийн чихний чимэг"¹⁹⁶ юм. Уг номыг VII Далай лам Галсанжамц \Bskal bzang rgya mtsho\ /1708-1757/ XVIII-р зуунд модон бараар сийлүүлэн төгсгөлийн үгийг бичиж гаргаж байсан ба XX-р зууны дунд үед бас барлагдсан бөгөөд тус хоёр бар нь одоо Төвдийн

¹⁸⁵ 'dod pa 'jo ba

¹⁸⁶ О. Сүхбаатар. Илт өгүүлэх нэрийн асуудалд. 1980 он 64-р тал

¹⁸⁷ Snyan 'ag me long

¹⁸⁸ Dpag bsam 'khri shing

¹⁸⁹ Klu kun tu dga' ba

¹⁹⁰ Mngon brjod sna tshogs gsal

¹⁹¹ Tshig gter

¹⁹² Mngon brjod gser phreng rol pa

¹⁹³ Mngon brjod pad dkar phring ba

¹⁹⁴ Mngon brjod kyi bstan bcos skabs gsum gyi snying po

¹⁹⁵ Sde rin spungs pa 'ag dbang 'jigs grags бээр билгийн тооллын наймдугаар жарны усан бар жил буюу аргын тооллын 1482 онд төрөөд есдүгээр жарны дунд үе хүртэл амьдарч байжээ.

¹⁹⁶ Mngon brjod kyi bstan bcos mkhas p'i gna rgyan хэмээх өөрийн 40 насандаа билгийн тооллын есдүгээр жарны төмөр могой жил буюу аргын тооллын 1521 онд зохиожээ.

нийслэл Лхас \ lha sa \ хотод хадгалагдаж байна. Тус ном үндсэн 4 бүлэг, 4 аймаг, 22 зүйлээс бүрджээ.

Нэгдүгээр бүлэг. Өндөр язгуурын аймаг.

1. Бурхан ба Бодьсадба тэргүүтний ёгт нэрийн зүйл.
2. Тэнгэр тэргүүтний ёгт нэрийн зүйл.
3. Огторгуй тэргүүтний ёгт нэрийн зүйл.
4. Цаг лугаа галав тэргүүтний ёгт нэрийн зүйл.

Хоёрдугаар бүлэг. Доод газрын аймаг.

1. Доод газар ба там бирд тэргүүтний ёгт нэрийн зүйл.
2. Ус ба усны амьтан тэргүүтний ёгт нэрийн зүйл.
3. Сал онгоц ба лянхуа тэргүүтний ёгт нэрийн зүйл.

Гуравдугаар бүлэг. Дэлхийн аймаг.

1. Газар тэргүүтний ёгт нэрийн зүйл.
2. Уул тэргүүтний ёгт нэрийн зүйл.
3. Хот айл тэргүүтний ёгт нэрийн зүйл.
4. Ой ба эм тэргүүтний ёгт нэрийн зүйл.
5. Араатан ба гөрөөс тэргүүтний ёгт нэрийн зүйл.
6. Шувуу тэргүүтний ёгт нэрийн зүйл.
7. Хүн тэргүүтний ёгт нэрийн зүйл.
8. Барамсай тэргүүтний ёгт нэрийн зүйл.
9. Хааны язгуур тэргүүтний ёгт нэрийн зүйл.
10. Ноёны язгуур тэргүүтний ёгт нэрийн зүйл.
11. Доордос язгуур тэргүүтний ёгт нэрийн зүйл.

Дөрөвдүгээр бүлэг. Нийтийн аймаг.

1. Оюун ухаан тэргүүтний ёгт нэрийн зүйл.
2. Хүслийн таван эрдэм тэргүүтний ёгт нэрийн зүйл.
3. Чөтгөр тэргүүтний ёгт нэрийн зүйл.
4. Утга бүгдийн хязгаар тэргүүтний ёгт нэрийн зүйл.

Гүн ухаан, бодь мөрийн зэрэг, тарни, зан үйл, яруу найраг, эвсэн найруулга, ёгт нэрийн чиглэлээр 6 боть зохиосон Төвдийн эрдэмтэн Үлчүламачойсан \ dngul chu bla ma chos bzang \ буюу Дармабадраагийн \ dha rma bha dra \ / 1772-1851/ бүтээл “Ёгт нэрийн шашдир далайн усны дусал”¹⁹⁷ хэмээх номонд саяхан Норовдадүл \ nor bu drga 'dul \, Цэрэннамжал \ tshe ring nam rgyal \ нар тайлбар хийж “Ёгт нэрийн шастир далайн усны дусалын тайлбар саруул оюунтаны хэлний толь хэмээх оршвой”¹⁹⁸ ном гаргажээ.

Хөх нуурийн дээд Монгол, Эрдэнэ бандида сүмбэ ханба Дорждашийн \ rdo rje bgra shis \ Ишбалжорын \ yi shes dpal 'sbyor \ / 1704-1788/ туурвисан

¹⁹⁷ Mngon brjod rgya mtshk'i chu thigs kyi rtsa 'grel Төвдийн номын үйлдвэр 1997

¹⁹⁸ Mngon brjod rgya mtshk'i chu thigs kyi rtsa 'grel blo gsal ngag gi me long zhes bya ba bzhugs so.

“Анагаах засал рашааны урсгалын харьяалал дотроос эм тус тусын илт өгүүлэхүй нэр ба түүнийг танин мэдэхүйн цагаан болор толь хэмээх оршвой”¹⁹⁹ гэдэг зохиол нь Монголын уламжлалт ангаах ухааны ёгт нэрийн анхны бүтээл юм.

Д.Ишбалжир нь Төвдийн анагаах ухааны сор бүтээл болсон “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын дөрвөн үндэс”²⁰⁰ судрыг V Далай лам Лувсанжамцын *blo bzang mrgya mtsho* тэргүүн эмчийн шавь Чойжилсанаар *l chos rgyal bzang* заалган анагаах ухаанд төгс гэгээрсэн төдийгүй улмаар өөрийн орны цаг агаар, уур амьсгал, ахуй амьдрал, ёс заншилд тохирсон 5 бүтээл туурвиж Монголын анагаах ухааны түүхэн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Түүний ёгт нэрийн зохиол нь эмийн нэрийн зүйл, эм тус бүрийг танин мэдэх ба амт чадлын номлол, гарын авлагын шимэнд хураасан зэрэг 3 бүлэгтэй. Эхний бүлэг эмийн нэрийн зүйлийг дотор нь хураангуй нэр ба тус тусын нэр хэмээн 2 хуваажээ. Тус тусын эмийн нэрийг дотор нь эрдэнийн, шороон, чулуун, модон, шимийн, тан, өвсөн, амьтны гаралтай гэж 8 хуваажээ. Бас “Үгийн чимгийн өчүүхэн хураангуй яруу найрагт орохын үүд”²⁰¹ “Яруу найргийн толиос номлосон чимэг нугуудыг үлгэрлэн хэлэх одны үзэсгэлэнт эрхэс ба нэрийн ил өгүүлэхийг өчүүхэн хураангуйлсан зандан эрхэн хүзүүвч”²⁰² зэрэг номонд яруу найргийн зарим ёгт нэрийг тайлбарласан бол “Одон, хар зурхайн зүрхний чандмань өчүүхэн хураасан бүхнийг тодотгогч толь”²⁰³ номонд зурхайн ёгт нэрийн нэр томъёог тайлбарлажээ.

Өвөр Монголын Цахарын хошууны гэвш Лувсанцүлтэм “Ёс арилгах тэргүүтний зургийг үйлдэх ёс өлзий хутгийн үүдийг нээгч” зохиолынхоо төгсгөлд зарим нэгэн тооны ёгт нэрийн тайлбарыг бичжээ.

Мөн Өвөр Монголын Найман хошууны гэнэн Жамбалдорж /XIX/ буюу Найман тойны бүтээл “Анагаан үйлдэгч рашааныг эндүүрэл үгүй танин барих урлахуй ухааны толинд тийн ургуулсан гайхамшигт үзэсгэлэнт нүдний чимэг хэмээх оршвой”²⁰⁴ ба “Ойман түнбэ” *ldngos sman 'krun dpe* нэрээр машид алдаршсан 174 хуудастай модон барын монгол эм судлалын иж бүрэн сонгодог зохиол юм. Уг зохиолд нийт 879 зүйлийн эмт бодисыг 8 аймаг, 24 төрөлд хувааж, 576 зурагт тайлбарыг дагалдуулжээ. Эмийн нэрсийг төвд монгол хятад 3 хэлээр эмт бодисын ургах газар орон, хэлбэр дүрс, амт чанар, чадал эмэнд орох хэсэг түүх цаг, номхотгох арга зэргийг нарийн тайлбарлажээ. Улмаар эмт бодисын тухай тайлбар зурагтай нь хавсаргасны дээр ёгт нэрийг бичсэнээрээ Монголын анагаах ухааны түүхэнд гайхамшигтай алдартай бүтээл болж чаджээ.

¹⁹⁹ Gso dpyad bdud rtsi'l chu rgyun gyi cha lag gi nang tshan gyi sman so so'l mngon brjod dang ngos 'dzin shel dkar me long zhes bya ba bzhugs so

²⁰⁰ Bdud rtsi snying po yan lag brgyad pa gsang pa man ngag gi rgyud bzhü II-р Манал бурхан гэж алдаршсан Төвдийн эмч бара Ютор Ендонгомбо бээр эмхэтгэн найруулсан бүтээл юм.

²⁰¹ Tshig rgyan nyung bsduṣ snyan ngag 'jug sgo

²⁰² Snyan ngag me long las bshad pa'l rgyan mams kyi dper brjod rgyu skar phreng mdzes dang ming gi mngon brjod nyung bsduṣ tsan dan ma ni'l do shal la

²⁰³ Skar nag rtsis kyi snying nor nyung bsduṣ kun gsal me long

²⁰⁴ Gso byed bdud rtsi'l 'krul med dngos 'dzin bzo rig me long du nam par shar pa mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so

Буриадын Цүүгэлийн дацангийн ширээт Дэлгэрийн Галсанжинбын \ skal bzang spyin pa\ “ Ил өгүүлэх нэр нугуудыг га-гийн эрхэст найруулсан шинэ оюунт гүмдаа цэцэг инээлгэх сарны гэрэл хэмээгдэх оршвой²⁰⁵” бүтээл нь төвд цагаан толгойн 30 үсгийн дарааллаар ёгт нэрийг түүж бичсэн 39 хуудастай буриад модон барын ном болно. Мөн дээр дурьдсан XIX-р зууны үед амьдарч байсан Агийн дацангийн 5-р дүрийн ширээт лам Гэлон \dge slong\ Галсанжинбын ХҮ-р жарны улаагчин туулай жил буюу аргын тооллын 1867 онд бичсэн “Эмийн сударт өгүүлсэн онжод нэрийн тайлбар оршвой” хэмээх 32 хуудастай, төвд цагаан толгойн дарааллаар дан ганц уламжлалт анагаах ухааны эмт бодосын ёгт нэрийг түүвэрлэн бичсэн ном байдаг байна.

Ёгт нэрийн хэрэглээ. Ёгт нэрийг бурхны шашны мэдлэг ухаанд өргөн ашиглагддаг. Ялангуяа яруу найраг, зурхай, тэжээхүй ухаануудад илт нэр нь гол байр эзэлнэ. Тиймээс эдгээр гурван гол ухаанд хэрхэн авч үздэг тухай дурдъя.

Эртний Энэтхэг, Төвдийн сонгодог яруу найраг нь өөрийн гэсэн тогтсон өвөрмөгц уран яруу тансаг үг хэллэг, зүйлэл чимэглэл, илт өгүүлэх нэрээр баялаг билээ. Үүний сацуу Монголын яруу найрагт ч бас ёгт нэрийг олонтоо хэрэглэж байсныг жишээ болгон дээр өгүүлсэн Дандар лхарамбын төвд хэлээр зохиосон “Хүмүүн номын баясгалангийн хурим хэмээх оршвой” гэдэг сургаалын шүлэгт гардаг зарим нэгэн ёгт үгийг энд өгүүлье. Уг зохиол нь Манжын төр гэрэлт хааны ширээнд суусан 10-р он, билгийн тооллын төмөр бар жил, 1830 онд бичигдсэн бөгөөд тухайн үеийн нийгмийн дээдэс, ноёд, баяд, сахил санваартан лам хувраг, жирийн ард түмний амьдрал дахь ёс суртахуунгүй бусармаг явдалд шүүмжлэлтэй хандсан сургаалын чанартай шүлэг юм. Тус номыг дацан хийдийн нэр орчуулгын сургалтанд заавал үздэг байсан, зартай хатуу хэмээн алдаршсаны учир нь номын хэл, хар ярианы хэл буюу айлын хэл, шинэ хуучин дохионы хэллэг, ёгт нэр зэргийг оруулсан байдагтай холбоотой. Ёгт нэрийн жишээг авч үзье.

Төвд эх:

མིང་ལག་འབྲུག་པོ་ནི་ལྷ་ལྷན་གྱི་རྒྱུ་བསྐྱེད་པ་འདི།

མེ་ཁུ་བུ་བའི་རྒྱུ་ལྷན་པོ་ལྷ་ལྷན་པོ་འདི།

དཔྱད་པར་ན་མུ་རྒྱུ་བསྐྱེད་པར་མི་ལོ་ལྷན་པོ།

ཕྱི་ལོ་ལྷན་པོ་བསྐྱེད་པོ་ལྷན་པོ་ལྷན་པོ་འདི།

Монгол орчуулга:

Хэдэн нэр дохио утгыг учруулахын тул өгүүлсэн энэ

Балчир хүүхдүүд хэлэлцсэн мэт барилдлагаа үгүй тул

Асар мэргэдийн мэлмийн өмнө үзүүлэх нь зохис үгүй ч

Зөрүүдээр өдүүлж түүнийг өчүүхэн төдий өгүүлж үйлдмүй.

Энэ дөрвөн мөртөд балчир хүүхдүүд гэдэг үг нь төвдөөр сэү жү ба \se'au bcu ba\ үгчилэн орчуулбал арван шүтэд буюу дөнгөж хөлд орж буй хүүхдийг хэлдэг, мэргэд гэдэг үг нь төвдөөр данван \dran dbang\ буюу үгчилэн орчуулбал

²⁰⁵ Mngon brjod kyi ming rnam ka 'phreng du bsgrigs pa blo gsar kunda bzhad p'l zl zer zhes bya ba bzhugs so

дурдахуйн эрхэт гэдгийг тус номын хатуу үгийн тайлбар²⁰⁶ зохиолд мэргэд /mkhas pa/, огоот баригч /yong 'dzin/ гэдэг үгсийн ёгт нэр гэжээ.

Төвд эх:

སའོན་ཀྱི་གཤམ་འདྲེན་ཆུ་གཏོར་ལུ་བཀྲིས་འདྲེན།

ཉིན་མཚན་སྟོན་པོ་ཆུ་ལང་བཟང་བྱིད་ཀྱང།

ཚད་མའི་ཆུ་སུམ་མ་བཟུག་ཀྱི་ཚེས་དུ།

དོན་མིད་བཟོ་ལྷ་གནང་ཡང་གཞུང་མི་བྱིད།

Монгол орчуулга:

Сүмбэр уулыг ч дамнуураар дамнаж, **сүн далайг** оочоор сорж

Наран саранг цанчилан хавсарч болох боловч

Бурхан шинжлэл үгүй гэнэдэж

Хэрэг үгүй дэмий балайг хэзээч зарлиглаагүй болой. Эдгээр мөртөд орсон төвдөөр сазин /sa 'dzin/ гэдэг үгийг орчуулбаас газар шороог баригч ба сүмбэр уулын ёгт нэр, төвдөөр чүдэрийг /chu gter/ үгчилэн орчуулбаас усан сан гэдэг нь далайн ёгт нэр, нинцан гонбууг /nyin mtshan mgon po/ орчуулбаас өдөр шөнийн итгэлт хэмээх нь нар сарны ёгт нэр, цадми жэвүг /tshad m'l skyes bus/ орчуулбаас шалгадаг төрөлхтөн нь Бурханы ёгт нэр билээ. Ийнхүү яруу найрагт хэрэглэгдэх ёгт нэрийн онцлог дээр өгүүлснээс харж болох юм.

Харин зурхайн ухаанд дөрвөн улиралын ёгт нэр, арван хоёр сарын ёгт нэр, шинийн ёгт нэр, долоон гаригийн ёгт нэр, хорин найман одны ёгт нэр, тооны ёгт нэр, жилийн ёгт нэр, жарны ёгт нэр зэргээр ил өгүүлэх нэрийг түгээмэл хэрэглэдэг байжээ. Жишээ болгон тооны ёгт нэрийг авч үзвэл нэгийн тоог мөн чанар /бүх юм ерөнхий нэг мөн чанартай байдаг/, дүрс /хүний дүрс/, сар, цагаан гэрэлт /сар бөгөөд сарны цагаан гэрэл нь сэрүүн ба халууны энэлгээг арилгагч юм/, туулайт /сарны ёгт нэр/, хоёрын тоог нүд, хос, арга билэг, хурьцагчид, гурвын тоог сансар хорвоо/ гурван хорвоо нь: хүслийн орон, дүрст орон, дүрсгүй орон/, гал /галын дөлийг гурав гэж билэгддэг/, ертөнц /анхдугаар нь тэнгэрийн ертөнц, хоёрдугаар нь газар дээрхи хүний ертөнц, гуравдугаар нь газар доорхи лусын ертөнц/, халуун /гурван халуун нь: бивилин, повари, эмийн гаа/, дөрвийн тоог далай /зовлонгийн дөрвөн далай: төрөх, өтлөх, өвдөх, үхэх/, тавын тоог хүслийн эрдэм /хүслийн таван эрдэм нь дүрс, дуу, үнэр, амт, хүрэлцэхүй/, сум /нэг саадагт таван сум байдаг/, цогц /таван цогц нь: дүрс, мэдрэл, хуран мэдэл, хуран үйлдэл, тийн мэдэл/, эрхтэн /таван эрхтэн нь нүд, чих, хамар, хэл, бие/, махбодь /таван махбодь нь: мод, гал, шороо, төмөр, ус/, зургаагийн тоог амт /зургаан амт нь: чихэрлэг, эсгэлэн, эхүүн, гашуун, давслаг, халуун/, цаг /их зургаан цаг нь: шинийн 8, 10, 15, 25, 29, 30/, завсар /зургаан завсар нь: хавар, дэгжилгэ, зун, намар, өвлийн эхэн, өвлийн адаг/, долоогийн тоог гариг /долоон гариг нь: адъяа, сумъяа, ангараг, буд, бархасбадь, сугар, санчир/, морь /долоон морь нь: хий, түргэн

²⁰⁶ Ишнажан “Суртгаал хүмүүнийг засагч баясгалангын хуримын дохиог үзүүлсэн мэргэн зочдыг дуудсан лавайн дуу эгшиг хэмээгдэх оршвой” 14 хуудас

сэтгэлт, таван өнгөт, дусалт, магад өгүүлэгч, машид ялгуулсан тэмдэгтэн, уулыг дарагч, наймын тоог тэнгэр \ найман их тэнгэр нь зүүн зүгт эрх баялагт, өмнө хурмаст, баруун цанба, хойно түгэн орогч, зүүн урд хүслийн эрх баялагт, баруун урд чуулганы эзэн элдэв заан, баруун хойно дунд риди, лус \ лусын 8 орон нь: баясгалан, ойрын баясгалан, тэгш баригч, жавхлант, морины шүтээн, орон нөхрийн сахиус, их хар, элийн навч, өлзий \ өлзий хутгийн найман шинж нь: эрднийн цагаан шүхэр, алтан загас, бумба, лянхуа, цагаан лавай, балбий, дуаз, хүрд, цогнойгч \ лусын ёгт нэр болой, могой \ могой нь лусын амьтан юм, есийн тоог сүв \ ам, хоёр чих, хоёр нүд, хамрын хоёр нүх, хошного, шээсний сүв, арвын тоог хилэнт \ нууц тарнийн номонд номлосон үүдийг сахигч арван хилэнт нь: эрлэгийн хаан, бусад бээр үл чадагч, морин хоолойт, рашааны эргүүлэг, үл хөдлөгч, хүслийн хаан, хөх бэрээт, их хүчит, оройн хүрдийг урвуулагч, хорлолд үзэсгэлэнтэй хаан, дууг дуурсгагч \ ерөнхий арван дуу дуурсгагч нь: заан, гөрөөс, бодь гөрөөс, илжиг, хон хэрээ, цагаан галуу, тахиа, галуу шувуу, хун шувуу, морин хараацай, зүг \ арван зүг нь дөрвөн зүг, дөрвөн зовхист, газар, тэнгэр \, тэгийг хоосон, огторгуй \огторгуй агаар мандал нь хоосон \ гэх мэтээр нэрлэжээ.

Тооны ёгт нэрийг бичихдээ тухайн тооны ижил тоот зүйлсын нэрийг сонгосон нь харагдаж байна. Зарим нэг зурхайн судрын хуудасны тоог ёгт нэрээр сар, нүд, эрдэм, далай, гал, амт гэх мэтээр дугаарласан байдаг. Бас нэгэн зурхайн бодолтонд орсон ёгт нэрийг авч үзье.

Монгол орчуулга: Жич хир үгүй хотол мандалыг

Гурван орон тавиад дээр нь **хоосон**

Далай ба **сараар** үржүүлээд доодохыг

Махбодь ба **хүрдээр чадагчаар** хуваа

Үлдэгдэл нь эрдэнийн эрхэсийн дүрсэнд буув.

Хоосон нь тэг, далай нь дөрөв, сар нь нэг, махбодь нь тав, хүрд нь хорин долоо, чадагч нь долоогийн тоо юм. Зурхайн ухаанд тоо, цаг хугацаа гэх зэргийг ёгтлон нэрлэдэг бол анагаах ухааны ёгт нэрэнд юуг хамруулан үздэгийг товчхон авч үзье.

Ютог Ёндонгонбын эмхэтгэсэн “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэс” зохиолын хоёрдугаар үндэс болох “Номлолын үндэс”-ний доторхи “Рашааны зүрхэн найман гишүүнт нууц увдисын үндэснээс амт хийгээд шингэхүйн эцсийг үзүүлсэн арван ёсдүгээр бүлэг”-т эмт бодосыг 8 бүлэгт хуваасан бол Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Эмт бодосыг танин мэдэж үйлдэх уялга үсэг” хэмээх номонд эрдэнийн эм, шороо, чулуу, модон, тан, шим, өвс, давсан, амьтны гаралтай, үнсэн эм гэх мэтээр 10 бүлэгт хуваажээ.

Эрдэнийн эмийн ёгт нэр. Гэнэн Жамбалдоржийн "Анагаагч рашааныг эндүүрэлгүй танин барих урлахуйн толинд нэн ургуулсан үзэсгэлэнт нүдний чимэг хэмээх оршвой" хэмээх номонд эрднийн эмийг дотор нь эс шингэх, шингэх гэж 2 хуваажээ. Эс шингэх эрдэнийн эмэнд хатуу чулуу, шил, далайн амьтны яс зэрэг орно. Ж: Нячи нь хясаа, загасны хацар \түүний өвчин анагаах чадал нь тархи цувирсаныг зогсоон, хор өвчнийг арилгана\ гэж орчуулдаг ба ёгт нэр нь сувдны хальс, сувд төрүүлэгч орон. Дун нь цагаан лавай \өгөрийг хатааж дүүрсэнийг нэвтэлэн, ясны халууныг арилгана\ ба цаст, арслангийн шүд, үхрийн шүд гэж нэрлэнэ. Шингэх эрдэнийн эмнээс алтыг \насыг уртатгаж, хөгшнийг чийрэг болгон эрдэнийн хорыг гаргана\ сайхан өнгөт, эрдэнийн гал, газрын саран, газрын зүрх, төмрийн дээд, мөнгийг \шар ус өвчин ба өгөр цусыг хатаана\ муухай өнгөт, цагаан өнгөт гэжээ.

Чулуун эмийн ёгт нэр. Жоншыг \суулгахыг зогсоон, бадганы халууныг арилгана\ шөнийн гэрэлт, бодын цагаан сэтгэлт, чулууны гүрвэл, сар, чулууны шим, соронзонг \зэв, төмрийг гарган, тархи яс, судлын өвчнийг арилгана\ төмрийг татагч, шунхыг \ярыг хураан, уушиг элэг судлын халууныг арилгана\ нар, асарын хөвгүүн гэжээ.

Шороон эмийн ёгт нэр. Шороон эмийг дотор нь өөрөө гарсан шороон эм, зассан шороон эм гэж 2 хуваана. Синдүрыг \судлын халуун, цул ярыг арилган, өгөр цусыг хатааж, галд түлэгдсэн шарханд тустай\ далайн хаг, үрийн цус, ямааг тогтоогч, шар хүхрийг \адыг даран, өгөр цусыг хатаана\ газрын цэцэг, газрын тунгалаг шимт, муухай үнэрт, үнэрт шар, чулууг дарагч, газрын шим гэжээ.

Шимийн эмийн ёгт нэр. Гаварыг \дэлгэрсэн халууныг аянга буух мэт нядлах, хуучирсан, шунасан халууны үндсээс гаргана\ үүлний шим, цасны ширхэг, цагаан гэрэлт, хөлсний шим, сарны үнс, сэрүүний шим, сар, арслангийн сүү, хүдрийн заарыг \хор, хорхой, бөөр, элэг, нян өвчнийг арилгана\ бор гавар, үнэрт хүйс, шимийн хаан, гөрөөсний хүйс, могойн хор, барагшүнг \халуун өвчин бүгд дор тустай, ялангуаа ходоод, элэг, бөөрний халууныг арилгахын дээд болой\ хадны шимт, хадны цус, умайн цус, хадны рашаан, газар дээрхи өвчнийг дарагч, хаднаас төрсөн, өрцний халууныг арилгагч гэжээ.

Модон эмийн ёгт нэр. Арүрыг \давслагаас бусад таван амт төгсгөсөн тул амьдруулж үйлдэх ба илчийг үүсгэж, идээг шингээн зохицуулж, хий шар бадганаас болсон өвчин бүхнийг дарна\ рашаант, амьдруулагч, өвчинг арилгагч, шимийг авахуулагч, сайн буянт, модны эрдэнэ, эмийн хаан, хорыг дарагч, жүрүрийг \бадгана, шар, цусны өвчнийг арилгана\ цангааг арилгагч, цусыг хатаагч, цусыг ялгагч, модны охин тэнгэр, үзэмийг \уушигний өвчнийг арилгаж, халууныг туулгана\ тачаагч үр, үнээний хөх, чихэрлэг амтат үр, зандангийн \цагаан зандан нь уушиг, зүрхний хямарсан халууныг арилгана, улаан зандан нь цусны халууныг арилгана\ ерөнхий ёгт нэр нь цэнгүүлэгч, цагаан занданг цогийн мод, сайхан цагаан, улаан занданг дилийн тосны навчит, навчин биет гэжээ.

Тан эмийн ёгт нэр. Анарыг \ходоодны өвчин бүгдийг хоцролгүй арилган, галын илчыг үүсгэж, бадгана хүйтэн өвчнийг дарна\ үрийн сан, элэгний өвчнийг дайсан, ходоодны ерөндөг, улаан чинжүүг \зидрагын хүч гал адил, галын элчийг үүсгэж, суваг хаван, хошногоны гөвдрүү, хорхой өвчин, хулгана яр өвчнийг арилгана\ хүчит гал, шатаагч галын бурхан, дигдийг \шарын халууныг арилгана\ гашуун, гахайн шийр, башагыг \цусны халууныг арилгана\ хүчжүүлэгч, цусыг хатаагч эрхэм, чихэр өвсийг \уушигний өвчин, судлын өвчнийг арилгана\ бал адил, чихэрлэг төгссөн найлзуур, хэл шарлуулагч, судас гүйлгэгч, уушигний ерөндөг гэжээ.

Өвсөн эмийн ёгт нэр. Үсүг \ходоодны бадгана халууныг арилгана\ цангааг арилгагч, зуун цэцэгт, сэржи мэдогийг \шарыг дээш татна\ өрмөн толгойт, өрмөн хошуут, гоньдыг \хий халуун хор хийгээд нүдний өвчнийг арилгана\ нүдний ерөндөг гэжээ.

Амьтны гаралтай эмийн ёгт нэр. Барыг \барын хатсан мах хутга мэсний шарханд тустай\ эрээн араатан, алаг биет, ирвэсийг \ирвэсний мах адын өвчнийг арилгана\ хар нохой, хар алаг зүст, хонийг \хонины яс хий өвчнийг арилгана, тойгны яс шээс хаагдсаныг арилгана, хуцны засаа хүчжүүлнэ, хонины тархи толгой эргэх, дүйрэхийг анагаана\ ноос төгөлдөр \ноост\, цагаан хишигт, гахайг \гахайн яс борыг арилгана, гахайн хэл хэмхэрсэн ясыг гаргана, гахайн цус хор ба тархсан борыг хураана, гахайн өөх хорыг хураан, нясууг арилгана, гахайн баас эс шингэсэн, нян хижиг, шарын бэтгийг арилгана\ тэнэг, ховхлогч, босоо үст, яст мэлхийг \яст мэлхийн зүрхээр толгойн шархыг анагаана\ таван мөчит, биеэ нуугч гэжээ.

Дүгнэн хэлэхүл, яруу найргийн ёгт нэр тухайн шүлэг зохиолыг уран үг хэллэг, зохиомж, хэтрүүлэг, ашиглан яруу тансаг болгодог бол, зурхайн ёгт нэр нь тооны нэрийг ерөнцийн ижил тоотой бусад зүйлтэй харьцуулан дүйж нэрлэхээс гадна тооны бодолт томьёололыг найруулга зүйн хувьд сонирхолтой болгодог ажээ. Эмт бодосын ёгт нэрийг ажиглавал тухайн бодосын хэлбэр дүрс, үзэгдэх байдал, өнгө, амт чадал, өвчин анагаах чадвар зэргийг харгалзан үзэж нэрлэсэн бол амьтны ёгт нэрийг амьтны өнгө, гадаад төрх, байгал дээр амьдрах чадвар, идэш хоолоо олж иддэг онцлог зэргээр бичжээ.

Анагаах ухааны дөрвөн үндэсний утгыг үл мэдэн ашиг хонжоо хайгчдаас болгоомжилж эмт бодосын зарим нэрийг ёгтоор нууцалж бичдэг билээ. Үүний адилаар яруу найраг болон зурхай зэрэг ухаанууд ч өөрийн гэсэн онцлог шинжтэй учраас янз бүрийн шалтгааны улмаас ийнхүү ёгтлон өгүүлдэг. Тиймээс бурхны шашин дэлхий дахинаа түгэн дэлгэрч, түүнийг сонирхон судлах нь ихэссэн өнөө үед бурхны шашны мэдлэг ухааныг судлахад суурь болсон ёгт нэрийг сонирхон судлаачдад уг судалгаа нь өчүүхэн ч гэсэн тус нэмэр болно гэдэгт найдаж байна. Цаашид ёгт нэрийн судалгааг илүү өргөн цар хүрээнд авч үзвэл зохилтой.

SUMMARY

The figurative name is the one of the 10 Buddhist Teachings, as well as serves as the main means to interpret the religious ideologies and doctrines. Therefore, nowadays the study of the figurative name, its types and features makes the significant contribution to the development of Buddhism which has spread out the world.

The figurative names in the poems use the phrases, literary forms and excess to make the poem more expressive and melodious, while the religious figurative names nominate things based on the comparison of the numerals with the similar numbers or other things and it makes the formula stylistically more interesting. To observe the figurative names of medicinal objects, they consider the general descriptions of medicinal objects, representing their shape, appearance, color, taste, quality, as well as their special magic for speedy recovery, while the figurative names of animals describe the colors, appearance, their ability to survive on the earth, and the special features of finding their food.

НОМ ЗҮЙ

1. Бүрнээ. Д, Энхтөр. Д, "Төвд Монгол илт өгүүлэх нэрийн толь". УБ., 2003, 502 х
2. Галсанжинба " Ил өгүүлэх нэр нугуудыг га-гийн эрхэст найруулсан шинэ оюунт гүмдаа цэцэг инээлгэх сарны гэрэл хэмээгдэх оршвой". Буриад бар,39 х.
3. Дэбаринбунба Агваанжигдаг. "Ёгт нэрийн шастир мэргэдийн чихний чимэг". Ардын хэвлэлийн хороо., 1999, 199 х.
4. Жамбалдорж. "Анагаан үйлдэгч рашааныг эндүүрэл үгүй танин барих урлахуй ухааны толинд тийн ургуулсан гайхамшигт үзэсгэлэнт нүдний чимэг хэмээх оршвой" Модон бар, 174 х.
5. Зая бандид Лувсанпэрэнлай. "Шагжийн тойн Лувсанпэрэнлайн гүнзгий ба агуу их дээдийн номын товъёог тодруулагч толиос нэгдүгээр боть оршвой". Бээжин бар, 297 х
6. Ишбалжор Д. "Анагаах засал рашааны урсгалын харьяалал дотроос эм тус тусын илт өгүүлэхүй нэр ба түүнийг танин мэдэхүйн цагаан болор толь хэмээх оршвой". Модон бар, 48 х.
7. Норовдадүл, Цэрэннамжал. "Ёгт нэрийн шашдир далайн усны дусалын тайлбар саруул оюунтны хэлний толь хэмээх оршвой" Төвдийн хэвлэлийн хороо., 1997, 297х.
8. Тэрбиш Л. "Зурхайн ухааны нэр, утгыг гийгүүлэгч түлхүүр толь бичиг". УБ., 2004, 186 х
9. Чимэдсэнгээ. "Ёгт нэрийн шастир үхэлгүйн гуу сан" Хөх нуурын ардын хэвлэлийн хороо., 1995, 157 х.
10. Ютог Ёндонгонбо "Рашааны зүрхэн найман гишүүнт нууц удисын үндэс". Хүрээ модон бар, 48х